

**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД,
НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

ХҮСНЭГТ 3.7

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	<p>Төвийн хэмжээнд мөрдөж буй буй бодлогын баримт бичиг /төвийн эрхэм зорилго, алсын хараа, Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт/- үүд, түүнийг хэрэгжүүлэхээр хийгдэж буй үйл ажиллагаа, үр дүн, статистик мэдээллийг цаг тухай бүрд <u>ЦССҮТ-ийн цахим хуудас</u>-д байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажилладаг.</p> <p>Мөн төвийн I, II байранд нийт 8 мэдээллийн самбараар тушаал шийдвэр, үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тухай бүр хүргэж, шинэчилж байна. 2024 онд:</p> <p>Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөө Эрхэм зорилго Алсын хараа Түүх Албан хаагчдын мэдээлэл Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт, хамрах хүрээ Нэгдсэн менежментийн тогтолцооны чанарын гарын авлага Нэгдсэн менежментийн тогтолцооны журам, ажлын заавар, стандарт ажиллагааны заавар ЦССҮТ-ийн үйл явцын зураглал Сар бүрийн статистик үзүүлэлт Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан Тэмдэглэлт өдрүүд, зохион байгуулсан арга хэмжээний удирдамж, тайлан зэргийг байршуулж мэдээллийн нээлттэй ил тод байдлыг хангаж ажилласан байна</p> <p><u>Алсын хараа, Эрхэм зорилго https://donor.mohs.mn/?p=17</u> <u>Сар, улирлын статистик мэдээ https://donor.mohs.mn/?p=6565</u> <u>УССҮТ-ийн тайлан, төлөвлөгөө https://donor.mohs.mn/?p=6813</u></p>	100%
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	<ul style="list-style-type: none"> ●Төвийн чиг үүрэг, танилцуулга мэдээллийг сайтын танилцуулга хэсгийн түүхэн замналаас дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжийг бүрдүүлсэн. ●Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн бүтэц, дүрмийг шинэчлэн батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/445 тушаалаар батлагдсан дүрэм, бүтцээр чиг үүргээ хэрэгжүүлж байна. 2024 онд төвийн бүтэц, дүрмийн шинэчлэх төсөл, 	100%

танилцуулгыг бэлтгэж холбогдох газарт хүргүүлсэн. Мэдээллийг сайтад байршуулж ил тод байдлыг хангасан.

●Төвийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах ажилтан, мэдээ мэдээллийг төвийн цахим хуудас, Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт- болон Цус сэлбэлт судлалын үндэсний төв -Facebook- хуудсаар албан ёсоор мэдээлж, үйлчлүүлэгчийн хандалт болон мэдээ, мэдээллийн шинэчлэлийн байдалд жилд 1-2 удаа тогтмол дүн шинжилгээ хийн, хяналт тавьж ажиллаж байна.

●Цус сэлбэлт судлалын салбараар үйлчлүүлсэн цусны донор үйлчлүүлэгчдийн цусны бүлгийн мэдээллийг E-Mongolia системээр харах боломжтой ба 2024 оны байдлаар давхардсан тоогоор нийт 52084 донор, үйлчлүүлэгч цусны бүлгийн мэдээллээ харсан байна. Мөн энэ хугацаанд E-Mongolia системээр харах боломжтой шинэ Цусны донор, үйлчлүүлэгчдийн цусны бүлгийн 36343 мэдээлэл нэмэгдсэн байна. 2023 онтой харцуулхад 123 хувь болж өссөн байна

●Донорын бүртгэлийн мэдээллүүдийг оруулах үед бүртгэлийн ажилтны оруулж буй мэдээлэл донорт ил тод байх боломж олгож дотоод сайтын офлайн болон онлайн горимд ажиллах хөгжүүлэлтийг нэвтрүүлсэн.

●Цусны Донор аппликейшн нь хэрэглэгчдэд дараагийн цус өгөх хугацаа, цусны бүлэг, нийт цус өгөлтийн тоо, цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээний хариу, дараагийн цус өгөлтийн хугацаа зэрэг мэдээллүүдийг хурдан авах боломжийг олгодог. 2024 онд дараах байдлаар хөгжүүлэлт хийгдэж байна.

- Гадны төлбөртэй серверт байршиж байсан Цусны донор аппликейшныг төвийн серверт байршуулж, жилд төлдөг 2 сая орчим төгрөгийг хэмнэсэн.

- 2022 оноос системийн шинэчлэл хийгдээгүй байсныг шинэчлэн сүүлийн үеийн IOS, android үйлдлийн системд ажиллах боломж бүрдүүлсэн.

- Явуулын хэлбэрээр цус цуглуулах төлөвлөгөө, байгууллагын нэр, байршил, цус цуглуулах цагийн хуваарийг харах боломжийг олгосон.

- Цусаар дамжих халдварын шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд Баянзүрх төв дээр өөрийн биеэр очиж шинжилгээний харууг авна уу гэсэн мэдээлэл гаргадаг болгосон. Аппликейшн хэрэглэгчийн тоо 24 хувиар нэмэгдсэн.

Өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах сувгуудын мэдээллийг байгууллагын вэбсайт, суурин төвүүдийн мэдээллийн самбарт ил тод байршуулсан.

<https://donor.mohs.mn/?p=1362>

Ажлын өдрүүдэд Үйлчилгээний санал, өргөдөл, гомдлыг шалган бүртгэх багийн гишүүд үйлчлүүлэгч хүлээн авч уулзах хуваарийг Сүхбаатар, Баянзүрх цус цуглуулах төвийн мэдээллийн самбарт ил тод байршуулсан.

		2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар төвийн 70112857 утсаар 988 дуудлага хүлээн авч, дуудлага болгоны утгыг тэмдэглэл хөтлөлт хийж, хариу өгсөн. Утасны дуудлагын тайланг улирал тутам удирдлагын багт тайлагнасан.	
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;	<p>Санхүүгийн тайлангийн 2023 оны жилийн эцсийн дүн мэдээ 2024 оны 02 сарын 23-нд гарсан бөгөөд санхүүгийн тайлагналын хувьд ноцтой зөрчил байхгүй гэж үзэн "Өөрчлөлтгүй" санал дүгнэлтийг өгсөн. Актгүй ажилласан бөгөөд 3 зөвлөмж, 4 албан шаардлага өгөгдсөн. Дээрх албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт 93,7 хувьтай биелэгдсэн ба биелэлтийг Үндэсний аудитын газарт бичгээр, (shilendans.gov.mn), Төрийн аудитын fas.audit.mn цахим системд биелэлтийн талаарх тайлбар pdf хэлбэрээр байршуулж нээлттэй байдлыг хангасан.</p> <p>Төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, дотоод аудитын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмж, Эрүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын аудитын үнэлгээ, дүгнэлт зөвлөмжийг сайтад ил тод нээлттэй байршуулсан.</p> <p>Төв нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 45001:2018 стандартын хэрэгжилтэд тогтмол хандлагын болон дотоод аудитыг баталгаажуулах, магадлах чиглэлээр жил бүр хамрагдан аудитын тайланг ЦССҮТ цахим хуудаст байршуулан ажиллаж байна.</p>	100%
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;	2018 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан Донорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж, гүйцэтгэсэн. Цусны донорын тухай хуулийн төсөл, үнэлгээний тайлан, бусад холбогдох материалыг dparliament.mn -д байршуулсан.	100%
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг 2022 онд батлуулсан. 2024 онд Эрүүл мэндийн яамнаас байгууллагуудын стратеги төлөвлөгөөний явцад хяналт, үнэлгээ хийж тайлан зөвлөмжийг ирүүлсэн. ЦССҮТ 88,4%-ийн үнэлгээтэй стратеги төлөвлөгөө батлуулан хэрэгжүүлж буй байгууллагуудаас УГТЭ-ийн дараагаар үнэлэгдсэн. Үнэлгээний тайлан зөвлөмжийг сайтад байршуулж, нээлттэй байдлыг ханган, стартаеги төлөвлөгөөнд тодотгол хийхээр төлөвлөж байна.	100%

1.6	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;</p>	<p>Тус төв нь:</p> <ul style="list-style-type: none"> ● Монгол улсын хууль 28 ● УИХ-ын тогтоол 3 ● Ерөнхийлөгчийн зарлиг 2 ● Засгийн газрын тогтоол 8 ● Олон улсын болон үндэсний стандарт 14 ● Засгийн газрын албан даалгавар 1 ● Төрийн албаны зөвлөлийн зөвлөмж 1 ● ЭМ-ийн сайдын тушаал 55 ● Сангийн сайдын тушаал 2 ● Хөдөлмөрийн сайдын тушаал 1 ● Ерөнхий захирлын 164 тушаал ● Ерөнхий журам 47 ● Нэгдсэн лабораторийн журам 23 ● Үйл явцын тодорхойлолт 9 ● Стандарт ажиллагааны заавар 84 ● Тоног төхөөрөмжийн ажлын заавар 33 ● Ажлын заавар 59 ● Маягт, бүртгэл 185 ● Хяналтын хуудас 35-г үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн баримт бичгийн нэгдсэн жагсаалт гарган ажиллаж байна. <p>ЦССҮТ-ийн https://donor.mohs.mn/ вэб сайтын хууль эрхзүй цэсэнд үйл ажиллагаандаа мөрдөж буй Хvvvль https://donor.mohs.mn/?p=569</p>	100%
1.7	<p>Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эхийн нр, өөрийн нэр, албаны харилцах</p>	<p>ЦССҮТ-ийн Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтын хүрээнд 9 алба, тасгийн 35 албан тушаалын тодорхойлолтыг https://donor.mohs.mn/ веб сайтын ил тод байдал цэсэнд https://donor.mohs.mn/?p=7022 байршуулан, нийт 26 ажилтан /алба, тасгийн дарга эрхлэгч, эмч мэргэжилтнүүд/-ы эцэг /эхийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны</p>	100%

утасны дугаар, албаны цахим шуудангын хаяг;

дугаар, албаны цахим шуудангийн хаягийг төвийн <https://donor.mohs.mn> вэб сайтны танилцуулга цэсэнд ЦССҮТ-ийн алба хаагчдын мэдээлэл <https://donor.mohs.mn/?p=6971> хаягтайгаар байршуулан тогтмол хяналт тавин ажиллаж байна.

ЦССҮТ-ийн албан хаагчдын мэдээлэл

№	Албан тушаал	Свог нэр	Е-мэйл
Захиргаа, маркетингийн алба			
1	Ерөнхий захирал	Н.Ордынбаяр	erdenebayar.n@nctm.mohs.gov.mn
2	Захиргаа, маркетингийн албаны дарга	Ч.Батболд	batbold.ch@nctm.mohs.gov.mn
3	Маркетинг, мэдээллийн зурвэл хондлогч	Д.Дулмаа	dulmaa.d@nctm.mohs.gov.mn
4	Хэргийн засагч-статистикч	Ш.Сойлмох	soyolmukh.sh@nctm.mohs.gov.mn
5	Архив-бичиг хэргийн эрхлэгч	Б.Нанжидгар	nanjigar.bj@nctm.mohs.gov.mn
6	Хүний нөөцийн менежер	Ч.Энхарталмаа	jenhartalma.ch@nctm.mohs.gov.mn
Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба			

Та ЦСҮ Салбэлт Судлалын Үндэсний Төвийн Тусламж Үйлчилгээг Үнэлэх Судалгаанд Камрадтана Уу.

Та ЦСҮ Салбэлт Судлалын Үндэсний Төвийн Тусламж Үйлчилгээг Үнэлэх Судалгаанд Камрадтана Уу.

Та ЦСҮ Салбэлт Судлалын Үндэсний Төвийн Тусламж Үйлчилгээг Үнэлэх Судалгаанд Камрадтана Уу.

ДОНОР ДОРГО

3 CAP 2 CAP

Албан тушаалын тодорхойлолт

- Захиргаа, маркетингийн алба
- Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн алба
- Цусны чанар, аюулгүй байдлын алба
- Санхүү бүртгэлийн алба
- Сувилахуй үйлчилгээний алба
- Донор зохион байгуулалтын тасаг
- Үйлдвэрлэлийн тасаг
- Нэгдсэн лабораторийн тасаг
- Инженер, техникийн тасаг

Та ЦСҮ Салбэлт Судлалын Үндэсний Төвийн Тусламж Үйлчилгээг Үнэлэх Судалгаанд Камрадтана Уу.

Та ЦСҮ Салбэлт Судлалын Үндэсний Төвийн Тусламж Үйлчилгээг Үнэлэх Судалгаанд Камрадтана Уу.

Та ЦСҮ Салбэлт Судлалын Үндэсний Төвийн Тусламж Үйлчилгээг Үнэлэх Судалгаанд Камрадтана Уу.

ДОНОР ДОРГО

1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	<p>Өргөдөл гомдол, санал хүсэлт хүлээн авах сувгуудын мэдээллийг байгууллагын вэбсайт, суурин төвүүдийн мэдээллийн самбарт ил тод байршуулсан. https://donor.mohs.mn/?p=1362</p> <p>Ажлын өдрүүдэд Үйлчилгээний санал, өргөдөл, гомдлыг шалган бүртгэх багийн гишүүд үйлчлүүлэгч хүлээн авч уулзах хуваарийг Сүхбаатар, Баянзүрх цус цуглуулах төвийн мэдээллийн самбарт ил тод байршуулсан.</p> <p>Тайлант хугацаанд Цусны аюулгүй байдал, төвийн үйл ажиллагаатай холбоотой болон ажилтан албан хаагчдаас бусад төрлийн асуудлаар нийт 141 өргөдөл гомдол, санал хүсэлт ирснээс 138 өргөдөл хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгсөн. Судлагдаж байгаа, хуулийн хугацаа болоогүй-3 өргөдөл хүсэлт байна.</p> <p>Тус төвийн 2024 оны Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн I-III улирлын тайланг тус тус албан бичгээр ЭМЯ-ны ТЗУГ-т хүргүүлсэн. IY улирлын тайланг 12 сарын 22-ны дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.</p>	100%
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;	<ul style="list-style-type: none"> - 2024 онд сарын бүрийн статистик мэдээг гарган, дүн шинжилгээ хийж, удирдлагын шуурхай зөвлөгөөн дээр танилцуулж, мэдээллээр тогтмол хангасан. Өдөр тутмын статистик тоон мэдээ гаргаж төвийн дотоод рүүппэд байршуулж мэдээллийн шуурхай ил тод байдлыг хангаж, шийдвэр гаргах боломжоор бүрэн хангасан. - Сар бүр үйл ажиллагааны статистик үзүүлэлтийг гарган дүгнэлт хийж, мэдээллийн самбар болон цахим хуудас, вэб сайтад тогтмол байршуулдаг. - Цусны албаны сүүлийн 5 жилийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэн баяжуулж “Эрүүл мэндийн үзүүлэлт 2023” эмхэтгэлд 2023 оны онцлох үйл ажиллагааны хамт хэвлүүлсэн. - Азийн хөгжилтэй орнуудын цусны албаны жишгээр Цусны алба-2023 эмхэтгэлийг монгол, англи хэл дээр бэлтгэн гаргаж, цусны салбар төв, гэрээт эмнэлгүүд, хэрэглэгчдийг бодит мэдээллээр хангаж, мэдээний санг баяжуулсан. - Уламжлал болгон зохион байгуулладаг эрдэм шинжилгээний бага хуралд “Цусны донорын эмчийн үзлэгийн тоог зарим эмнэлгүүдийн амбулаторийн үзлэгийн тоотой харьцуулсан судалгаа” сэдэвт УХТЭ, УГТЭ, ЦССҮТ, Монгол-Японы сургалтын эмнэлэг, Орхон аймаг дахь БОЭТ, Завхан аймгийн Нэгдсэн эмнэлэг зэрэг эмнэлгүүдийн мэдээллийг судалгаанд хамруулан судалгаа боловсруулсан. 2024 оны 	100%

		10 сарын 17-ны өдөр зохион байгуулагдсан Цусны албаны эрдэм шинжилгээний XXI бага хуралд аман илтгэл хэлэлцүүлж, илтгэлийн хураангуйд хэвлүүлсэн.	
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.	<p>Чиг үүргийн дагуу зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээний мэдээллийг Төвийн цахим хуудас, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв, Амьдрал бэлэглэе пэйж хуудас, Донор та баатар Фейсбүүк групп хуудсанд тогтмол байршуулж нээлттэй байдлыг хангаж цусны донорын сурталчилгаа маркетингийг хийдэг. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн санаачилгаар жил бүрийн 1 дүгээр сарын 3-ныг “Цусаа бэлэглэх үндэсний өдөр” болгон тэмдэглэж, ард, иргэдийг цусаа бэлэглэх донорын үйлсэд уриалан цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын тоог нэмэгдүүлэх, донорын үйлсийг сурталчлах, олон нийтэд алдаршуулах арга хэмжээг зохион байгуулдаг. 2024 оны Цусны донорын Үндэсний өдөр тэмдэглэх удирдамж, төсвийг ерөнхий захирлын 2024 оны А/20 тушаалаар баталж хөтөлбөрийн дагуу арга хэмжээг зохион байгуулсан. Хүндэтгэлийн арга хэмжээний мэдээллийг Төвийн цахим хуудас, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв, Амьдрал бэлэглэе пэйж хуудас, Донор та баатар Фейсбүүк групп зэрэг социал орчинд болон хэвлэл мэдээллийн байгууллагаар мэдээлсэн. - 2024 оны “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийн 20 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг “Амьдрал бэлэглэсэн 20 жил: Цусны донор танд баярлалаа” уриан дор ДЭМБ-ын дэмжлэгээр зохион байгуулсан. Арга хэмжээнд Эрүүл мэндийн яамны эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга, МУЗН, МДХ-ны хүндэт зочид, бусад байгууллага хамт олны төлөөлөл, хүндэт донорууд, улаан загалмайчид, ОУ-ын байгууллагын төлөөлөл оролцсон. Азийн цус сэлбэлтийн холбооноос цусны донорын Дэлхийн өдрийн 20 жилийн ойн арга хэмжээг нийт гишүүн орнуудыг оролцуулан нээлттэйгээр шууд дамжуулж, бусад улс орнуудын туршлагыг хуваалцсан. Цус сэлбэлт судлалын үндэсний төв пэйж хуудсаараа шууд дамжуулж мэдээлэл сурталчилгаа хийсэн. <u>Арга хэмжээний мэдээллийг</u> Төвийн цахим хуудас, Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв, Амьдрал бэлэглэе пэйж хуудас, Донор та баатар Фейсбүүк групп хуудсанд байршуулсан. - Сар бүрийн 3 “Цусаа бэлэглэх өдөр”-ийн арга хэмжээг 11 удаа үйл ажиллагааг Наран фүүдс, БЗД-ийн ЗДТГ, ИТХ-ын Ажлын алба, УЗДШХ, МУЗН, Наран фүүдс Ulker Mongolia, Үнэртэй усанд дурлагсдын клуб, Улаанбаатар Смарт карт ХХК, МДХ ТББ, Улаан загалмайн Хүүхэд Залуучуудын Хөдөлгөөн зэрэг байгууллагууд дэмжиж хамтран зохион байгуулж, цусны байнгын доноруудыг шагнаж алдаршуулсан байна. Сар бүрийн 3 цусаа бэлэглэх өдрөөр иргэд, байгууллага хамт олны төлөөлөл нийт 1738 донор цусаа бэлэглэж хүмүүнлэгийн үйл ажиллагаанд 	100%

		<p>нэгдсэн. Энэ өдөр цусаа бэлэглэсэн хүндэт донор, тогтмол хугацаанд цусаа өгдөг байнгын доноруудын алдаршуулалтын мэдээллийг Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Амьдрал бэлэглэе пейж хуудас Донор та баатар группд байршуулж нийтэд хүргэсэн. Телевиз, Хэвлэл мэдээллийн байгууллагаар байгууллагын удирдлага, хүндэт донорууд ярилцлага өгч цусны донорын сурталчилгаа мэдээлэл хийсэн</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн вэб сайт, 2 пейж хуудас, 1 фейсбүүк группийг тогтмол ажиллуулж ДЭМБ, ЭМЯ, НЭМҮТ зэрэг байгууллагаас гаргасан тодорхой эх үүсвэртэй мэдээллийг иргэд, цусны доноруудад хүргэдэг. Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төв, Амьдрал бэлэглэе пейж хуудас, Донор та баатар групп хуудсанд нийт 132 эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж, мэдээллийг давхардсан тоогоор 262 удаа байршуулан ард иргэдэд хүргэсэн. Пейж хуудасны дагагчийн тоо 53000 болж, хандалтын тоо 51.8 %-иар тус нэмэгдсэн. 4580 ширхэг тараах материал түгээсэн. 3280 төрийн албан хаагч, 235 сайн дурын идэвхтэн, 10182 оюутан 240 сурагчдад танхим, онлайнаар зөвлөмж мэдээлэл хүргэсэн. - 2024 оны байдлаар “Амьдрал бэлэглэе” фейж хуудсанд цусны донорын талаарх зөвлөмж мэдээлэл-114, донор алдаршуулалтын мэдээлэл-79, зарлал мэдээлэл-26 нийт 219 мэдээлэл оруулж түгээсэн. Гишүүнчлэлийн тоо 10844 болж 44 хүнээр нэмэгдсэн. Хандалтын тоо 22%-иар нэмэгдсэн. - 2024 оны байдлаар Донор та баатар групп хуудсанд цусны донорын талаарх зөвлөмж мэдээлэл-92, донор алдаршуулалтын мэдээлэл-52, зарлал мэдээлэл-36 нийт 180 мэдээлэл оруулж, 39200 хүнд хүргэсэн. Гишүүнчлэлийн тоог 12000-аас 14600 болгож 2600-аар нэмэгдүүлсэн. 	
Хэсгийн дундаж хувь:		100%	
Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	2024 оны жилийн эхэнд Захиргаа, маркетингийн албанд 1, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албанд 1, Сувилахуй, үйлчилгээний албанд 1, Үйлдвэрлэлийн тасагт 1, Нэгдсэн лабораторийн тасагт 1 /ХАЧ-тэй хүний оронд түр/ Донор зохион байгуулалтын тасагт 1, Цусны чанар аюулгүй байдлын албанд 1, нийт 7 сул ажлын байр байсан. Мөн 2024 оны эхнээс 3 дугаар улирлын эхэн хүртэл нийт 11 ажилтан өөрийн санаачлагаар, 1 ажилтан захиргааны санаачлагаар, 5 ажилтан хүүхэд асрах чөлөө авч нийт 17 ажлын байр сул гарсан. 2024 нийтдээ 24 сул ажлын байр гарч тухай бүрд нь ЭМХТ, (hrdc.gov.mn) ЦССҮТ, https://donor.mohs.mn/?p=1357 Zangia.mn	100%

сайтуудад "Сонгон шалгаруулалт явуулах журам"-ын дагуу ил тод байршуулан нөхөн хангалтыг 100 хувь хийсэн байна.



**АЖЛЫН БАЙРАНД
УРЬЖ БАЙНА**
ЛАБОРАНТ

Гүйцэтгэх үндсэн үүрэг:
**АЛБАН ТУВААЛИЙН ТАӨӨРХӨЙЛӨВСӨД
ЭВЭЛДЭН НЭГ ҮҮРГИЙН ДАГУУ**

Бурдуулах материал

- Төрийн албан хаагчид өргөмжлөл
- Боловсролын тусламж, хандлагын зориулалтаар тусламж үйлчилгээ
- Улсын гэрээний дагуу тусламж үйлчилгээ
- Нийгмийн ашигтай ажлын үр дүнд хандуулах зориулалтаар тусламж үйлчилгээ
- Ажилтны тусламж үйлчилгээ

Байршил



Утас: 9717166, 7915287
ЭХ ХЯМГААРИХ: 480-10000
ЦСЭТ-Т: 480000
Материал хувиар авалт: хувиар
2024 оны 9 дүгээр сарын 30-ны
18 цаг хүртэл

Ажлын байранд тавигдах шаардлага:

- Лаборантын ажилтан
- Сурт явжиг арилжааг тусгай эзэмшсэн ажилтан
- Ведомо Логон Банкар зөвхөнөөр хариуцаж өгөх ажилтан
- Ажлын явцаагт дансанд хариуцаж өгөх ажилтан
- Со сүй, харилцаа хийх ажилтан



**АЖЛЫН БАЙРАНД
УРЬЖ БАЙНА**
СУВИЛАГЧ

Гүйцэтгэх үндсэн үүрэг:
**АЛБАН ТУВААЛИЙН ТАӨӨРХӨЙЛӨВСӨД
ЭВЭЛДЭН НЭГ ҮҮРГИЙН ДАГУУ**

Бурдуулах материал

- Төрийн албан хаагчид өргөмжлөл
- Боловсролын тусламж, хандлагын зориулалтаар тусламж үйлчилгээ
- Улсын гэрээний дагуу тусламж үйлчилгээ
- Нийгмийн ашигтай ажлын үр дүнд хандуулах зориулалтаар тусламж үйлчилгээ
- Ажилтны тусламж үйлчилгээ

Байршил



Утас: 9717166, 7915287
ЭХ ХЯМГААРИХ: 480-10000
ЦСЭТ-Т: 480000
Материал хувиар авалт: хувиар
2024 оны 9 дүгээр сарын 30-ны
18 цаг хүртэл

Ажлын байранд тавигдах шаардлага:

- Сувилагчийн ажилтан
- Сурт явжиг арилжааг тусгай эзэмшсэн ажилтан
- Ведомо Логон Банкар зөвхөнөөр хариуцаж өгөх ажилтан
- Ажлын явцаагт дансанд хариуцаж өгөх ажилтан
- Со сүй, харилцаа хийх ажилтан



**ЦУС САЛБИЛТ СУДАЛЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

ЦУС САЛБИЛТ СУДАЛЛИЙН
СТАНДАРТ ХАМГААРИХ
БҮЙРГЭЛЭЛЭГ



Ашиглах өгөг:
Сайт: www.mca.gov.mn
Утас: 7711 3333, 7711 3334
Факс: 7711 3335

БҮҮХ ЭЗЭМШ, ТАВГААГУУЛА, ХЭРЭГЭРХЭЛ, СӨРӨГЭЙН, ИЛ ҮНД БАЙЛАЛ, ШИШЭН ДАМС, АЖЛЫН ЯВА ВУБ, БС ҮҮРЭГ САЛБИЛТ ХӨРӨНГ, ҮГЭ ХӨРӨНГ

Сүл ажлын байр

Сүл ажлын байр

Огноо	Мэргэжил
2024.09.11	Сүл ажлын байр: Лаборант
2024.09.11	Сүл ажлын байр: Сувилагч
2024.09.11	Сүл ажлын байр: БС үүрэг салбар хороонд хөгдөөгийн өндөр ажилтан
2024.06.24	Сүл ажлын байр: ИХ ТӨВ
2024.06.24	Сүл ажлын байр: Сувиллагч
2024.06.24	Сүл ажлын байр: Эдийн засагч
2024.06.08	Сүл ажлын байр: Бөөс тэвч тэнх, эдийн засагч
2024.06.08	Сүл ажлын байр: Сувиллагч
2024.06.12	Сүл ажлын байр: Бөөс тэвч тэнх, эдийн засагч
2024.03.12	Сүл ажлын байр: ИХ ТӨВ
2024.03.12	Сүл ажлын байр: Бөөс тэвч тэнх, эдийн засагч

**ЦУС САЛБИЛТ СУДАЛЛИЙН ҮНДЭСНИЙ
БҮЙРГ, ҮГЭ ХӨРӨНГ, ТАВГААГУУЛА
СУДАЛГААНД ХАМГААРИНА УУ!**


Та Цус салбилт судаллийн үндэсний төвөөс хувиар авалтаар өөрсдийн ажлын байр, үйл ажиллагаагаа цахим хуудалд хамгаарна уу!

Тус хуудалд ажлын байр, үйл ажиллагаагаа хамгаарна уу!

ДОНГО ДОНГО

Watch our YouTube channel

АВАРАТАА ТӨМӨР ҮНДЭСНИЙ
АЖЛЫН БАЙРАНД ХАНГААРИХ
СҮРТАЛТЫГ ХУВИАР АВАЛТ ҮҮРЖ БАЙНА

2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;	<p>ЦССҮТ-ийн "Сонгон шалгаруулалтын журам"-ын хэрэгжилтыг ханган ажиллаж байхын зэрэгцээ Шинээр томилогдсон ажилтныг "Дасан зохицох хөтөлбөрийн журам"-д заасны дагуу Чиглүүлэх сургалтад хамруулан, жинхлэн томилох асуудлыг шийдвэрлэж байна. Дээрх журмуудыг ЦССҮТ-ийн цахим хуудасны ил тод байдал цэсэнд https://donor.mohs.mn/?p=6975 байршуулсан.</p> 	100%
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	<p>ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/ вэб сайтын Ёс зүйн салбар хороо цэсэнд албан хаагчийн ёс зүйн дүрэм https://donor.mohs.mn/?p=4709 байршуулахаас гадна Төвийн ёс зүйн салбар хорооны самбарт дараах мэдээллийг байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> ● Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм 2019 оны 406 тоот тушаал ● Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл ● Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм ● 2019 оны Засгийн газрын 33 тогтоол ● Төвийн мөрдөж ажиллах зарчим ● Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн тулгуур зарчим 	100%

		<p>ЁЗСХ тайланг хагас жил, бүтэн жилээр ЭМЯ ЁЗХХ илгээсэн. Мөн ЦССҮТ-ийн дэргэдэх ёс зүйн салбар хорооны хөндлөнгийн гишүүнийг сонгон шалгаруулан авах зарыг төвийн цахим хуудсанд 3, 4 дүгээр улирлуудад байршуулан сонгон шалгалуулах ажлын хэсгийн ЭМ-ийн сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу Ерөнхий захирлаар томилуулан ажиллаж байна.</p>	
2.4	<p>Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам</p>	<p>Хүний нөөцийн хөгжлийг хангах 2024 оны төлөвлөгөөний биелэлт 100% хэргэжсэн байна. Байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтийг 100% байлгаж, холбогдох сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн мэргэшсэн хүний нөөцөөр нөхөн хангахад анхааран ажиллаж байна.</p> <p>Хөдөлмөрийн хууль /шинэчилсэн найруулга/-тай уялдсан Хамтын гэрээ байгуулан бүртгүүлж, Хөдөлмөрийн дотоод журам, түүнтэй уялдан гарах Сонгон шалгаруулалтын журам, Хүний нөөцийн төлөвлөлтийн журам, Дасан зохицох хөтөлбөрийн журам, ЦССҮТ-ийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр, Мөнгөн урамшууллын журам, Сургалт хөгжлийн журам, Цалин хөлсний журам, Шагнал урамшууллын журам, Ур чадварын нэмэгдэл олгох журам батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>Төвийн ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/ вэб сайтын ил тод байдал цэсний хүний нөөцийн удирдлагын ил тод байдал хэсэгт https://donor.mohs.mn/?p=4714, https://donor.mohs.mn/wp-content/uploads/2022/11/Dasan-zohitsoh2022.pdf дээрх журам, хөтөлбөрүүдийг байршуулсан.</p>	100%
2.5	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ</p>	<p>Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр Хүний нөөцийн төлөвлөлтийн, Сонгон шалгаруулалтын, Дасан зохицох хөтөлбөрийн журам, ЦССҮТ-ийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр, төлөвлөгөө батлан байгууллагын вэб хуудсанд ил тод байршуулж байна. Төвийн https://donor.mohs.mn/?p=4714 вэб сайтад байршуулсан. https://donor.mohs.mn/wp-content/uploads/2022/11/Dasan-zohitsoh2022.pdf -д байршуулсан</p>	100%
2.6	<p>Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.</p>	<p>Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор Төвийн "Ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг шинэчлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллахын зэрэгцээ "Мөнгөн урамшууллын журам", Засгийн газрын тогтоол шийдвэрийг баримтлан Ажилтнуудын улирлын ажлын үр дүнгээр олгох урамшуулал, ур чадварын нэмэгдлийг холбогдох алба, тасгийн дарга, эрхлэгч, ажилтны санал, шийдвэрийг тусгах замаар ил тод хэрэгжүүлсэн.</p> <p>Дээрхи журамыг ЦССҮТ-ийн цахим хуудсны https://donor.mohs.mn/-ны Ил тод байдал цэсэнд https://donor.mohs.mn/?p=4714 байршуулсан</p>	100%
Хэсгийн дундаж хувь:			100%

Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх ил тод нээлттэй байдал

3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;	2023 оны аудитлагдсан санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Шилэн дансны цахим систем болон, Сангийн Яамны Э-тайланд шивж оруулсанаар, ЭМЯ, СЯ-ны нэгдсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн. Эрүүл мэндийн сайдын баталсан 2024 оны төсвийн хуваарийг шилэн дансанд байршуулан ил тод болгосон. 2024 оны 7 сард байгууллагын 2025 оны төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын саналыг цаасаар ЭМЯ-нд хүргүүлж, Сангийн яамны төсвийн болон хөрөнгө оруулалтын нэгдсэн программд шивж оруулсан. 2025 оны төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан зардлыг төлөвлөлөө. 2025 оны төсвийн төсөлд нийт 13.8 тэрбум төгрөгийн төсвийн саналыг боловсруулж хүргүүлсэн. <u>2023 оны төсвийн гүйцэтгэл, 2024 оны батлагдсан төсөв, 2025 оны төсвийн төсөл, 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлүүдийг цаг тухай бүр нь Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим систем, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/, байгууллагын ил тодын самбарт тус тус байршуулсан.</u>	100%
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээ, өглөг, авлагын мэдээг дараа сарын 2-ны дотор ЭМЯ-ны төрийн санд хүлээлгэн өгч, шилэн дансны цахим системд тоон мэдээллээ оруулж, баталгаажсан тайланг скайнердаж хавсралтаар оруулж ажилласан. 2023 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлан, 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг Э-Тайлан цахим системд оруулж, ЭМЯ хүлээн авч баталгаажуулсан. Мөн <u>Шилэн данс (shilendans.gov.mn) цахим систем, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/-д баталгаажсан санхүүгийн тайланг pdf хэлбэрээр хуулинд заасан хугацаанд нь байршуулсан.</u>	100%
3.3	Санхүүгийн Тайланд хийсэн аудитын дүгнэлт;	ЦССҮТ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Баян суварга аудит” ХХК аудиталсан бөгөөд материаллаг томоохон хэмжээний алдаагүй, үнэн зөв толилуулсан гэж үзэж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн ба аудитын актгүй ажиллалаа. Санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн бүртгэлийн ажлыг сайжруулах 3 зөвлөмж, 4 албан шаардлага өгсөн бөгөөд асуудлыг шийдвэрлэх төлөвлөгөө гарган тус төвийн ерөнхий захирлаар батлуулан биелэлтийг хангаж ажиллалаа. Санхүүгийн тайлан, дүгнэлтийг <u>Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд болон, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/, байгууллагын ил тодын самбарт байршуулж, алдаа зөрчлийн талаар авч хэрэгжүүлсэн ажлын төлөвлөгөө, биелэлтийг Үндэсний аудитын газрын fas.audit.gov.mn онлайн программд оруулсан нь хяналтын шатанд явж байна.</u>	100%
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	Тус төвөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээ, бүтээгдэхүүний төлбөрт Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 49,А/118 дугаар тушаалын үнэ тарифыг, цэвэр бохир усны төлбөрт 2023 оны 10 сард шинэчлэгдсэн үнэ тарифыг, гэрэл цахилгааны төлбөрт Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн шийдвэрээр 2024 оны 11 сарын 01-нээс шинэчлэгдсэн үнэ тарифыг мөрдөн	100%

		ажиллаж байна. Дээрх үнэ тарифын өөрчлөлтийг тухайн цаг хугацаанд https://donor.mohs.mn/ Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд байршуулсан.	
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Төсвийн зарцуулалтад Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд хэмнэгдэж байгаа зардлаар дутагдаж байгаа зардлыг нөхөхөөр гүйлгэн зарцуулах хүсэлтийг ЭМЯ-нд гарган ажиллаж байна. Төсвийн буруу хуваарилалтаас шалтгаалан зарим зардал хэмнэгдэх, зарим зардал дутагдах нөхцөл байдал үүсч байна. Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) , ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/ хуудсанд болон байгууллагын ил тодын самбарт байршуулсан.	100%
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;	ТБОНӨТ хуулийн босго үнийн болзлыг хангасан худалдан авч байгаа бараа ажил үйлчилгээнд тендер шалгаруулалт явуулж, гэрээ байгуулан зарцуулалтыг гаргаж байгаа ба Таван сая төгрөгөөс дээш худалдан авалтын мэдээг өссөн дүнгээр ЦССҮТ-ийн цахим хуудас https://shilendans.gov.mn , ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/ цахим хуудас, байгууллагын ил тодын самбарт байршуулан ажиллаж байна.	100%
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний утга, хүлээн авагчийн нэр, данс, регистрийн дугаар болон бусад холбогдох мэдээллийн хамт тухай бүр нь (shilendans.gov.mn) цахим систем, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/-д болон байгууллагын ил тодын самбарт байршуулж байна.	100%
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	ЦССҮТ-ийн хөрөнгө мөнгө захиран зарцуулахтай холбогдолтой тушаал шийдвэр, өр авлага үүсгэхтэй холбоотой (shilendans.gov.mn) цахим систем, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/-д хугацаа хоцроохгүйгээр байршуулан ажилладаг.	100%
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Шилэн дансны цахим системд жилд нийтдээ 171 мэдээллийг байршуулан ажилладаг бөгөөд 2024 оны 12 сарын 10-ны байдлаар 155 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээллэсэн байна. Үүнд аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл багтаж байна. Дээрх мэдээллийг ЦССҮТ-ийн ил тод байдлын мэдээллийн самбар, (shilendans.gov.mn) цахим систем, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/-д оруулж ажилладаг. Одоогийн байдлаар хоцорсон мэдээлэл байхгүй байна.	100%
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан https://user.tender.gov.mn/mn/admin/generalplan/1704820258683/index	100%

	оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Худалдан авах ажиллагааг зохион байгуулж tender.gov.mn сайтад тухай бүр мэдээллийг оруулсан. Шилэн дансны цахим системд болон, байгууллагын ил тодын самбарт байршуулсан. https://info.shilendans.gov.mn/ReportFormSettings/ReportOrganizationData	
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт;	Төвийн 2024 оны Үндэсний аудитын газраас гэрээ байгуулан сонгогдсон аудитын компаниар 2024 оны 10 сард засварын аудитын шалгалтад хамрагдсан. Шалгалтаар худалдан авах ажиллагаанд ямар нэг зөрчил илрээгүй болно. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн хэрэгжилтэнд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд тендерийн үнэлгээний хороонд хөндлөнгийн 2-оос доошгүй гишүүний оролцуулан зохион байгуулж хэвшсэн болно.	100%
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;	Тус төвийн чиг үүрэгт хамааралгүй болно.	
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн	2024 онд Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.	
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;	Яаралтай үед эмнэлгүүдийн цус, цусан бүтээгдэхүүний тээвэрлэлтэд нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг ашиглах, нэвтрүүлэх зорилгоор Япон улсын Ньюком групптэй 3 удаагийн уулзалт хийж сонгогдсон 3 эмнэлэгт дроноор 5 төрлийн 140 нэгж цус, цусан бүтээгдэхүүн (38,259 мл)-ийг 50 удаагийн нислэгээр хүргэсэн. Нэг талдаа нислэгийн дундаж хугацааг тооцоход: <ul style="list-style-type: none"> - Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс- АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлэг маршрутын дагуу 11 минут. - Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс –Амгалан амаржих төрөлжсөн мэргэжлийн төв маршрутын дагуу 6 минут. - Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс- ЭХЭМҮТ маршрутын дагуу 9 минут. Дээрх нислэгийг хийхэд иргэний нисэхийн ерөнхий газраас зөвшөөрөл авч, туршилтын нислэгүүдийг амжилттай хийсэн. Ингэсээр хотын түгжрэл, цаг хугацаа, түлш шатахуун	100%

		зарцуулалт, эмнэлгийн ажилтны ажлын бүтээмж нэмэгдэх зэрэг олон талын ач холбогдолтой.	
3.15	Хууль тогтоомжид заасан бусад.	ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын нийтийн мэдээлийн ил тод байдлын тухай хуульд нийцсэн хамаарал бүхий шийдвэрийг donor.mohs.mn цахим хуудсанд байршуулж ажилласан. Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлэх 4 компаний тендерт давхардсан тоогоор 31 хүний мэдэгдэл, 11 ажилтан хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэж мэдээлсэн байна.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдал			
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/ вэб сайтад ЭМС-ын 2022 оны А/117 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн ЭМБ-аас бусад эрүүл мэндийн байгууллага, ААНБ болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад 17 тусламж, үйлчилгээний жагсаалтыг болон Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 49/А/118 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн ЭМБ-аас бусад эрүүл мэндийн байгууллага, ААНБ болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний үнэ тарифыг байршуулсан бөгөөд тус төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөх жагсаалтыг ерөнхий захирлын тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. https://donor.mohs.mn/wp-content/uploads/2017/01/Une-2022.pdf	100%
4.2	Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно.	
Хэсгийн дундаж хувь:			

Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга,	<p>2023 оны 12 дугаар сард УИХ-д өргөн баригдахаар төлөвлөгдсөн Цусны донорын тухай хуулийн төслийг холбогдох материалын хамт байршуулж санал авсан.</p> <ul style="list-style-type: none"> ● “Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар” Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/03 шинэчлэн боловсруулах ажлын хэсэг тушаалын төсөл ● Донорт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах тухай Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны А/194 дугаар тушаал, ● “Цусны хүндэт донорыг сувилуулах тухай” Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/43 дугаар тушаалыг шинэчлэх журмын төслүүдэд байгууллага ажлын хэсэг байгуулах, удирдлагын багаар ярилцах, хамт олонд мэдээллэж санал авах байдлаар ил тод нээлттэй байдлыг хангаж хамтарч ажилласан. 	100%
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;	<p>Монгол улсын Оюуны өмч, улсын бүртгэлд төвийн бэлгэ тэмдэг Дорго, цусны донор алдаршуулалтын тэмдэг, сар бүрийн 3 цусаа бэлэглэх өдрийн лого зэрэг барааны тэмдгийг 2027 он хүртэл 10 жилийн хугацаатай бүртгүүлж эзэмшиж байна.</p> <p>ЦССУТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/ вэб сайтад байршуулсан https://donor.mohs.mn/?p=6880</p>	100%
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;	Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно.	
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;	Төвийн 1, 2-р байрны газрын гэрчилгээ, хуулийн этгээдийн газар эзэмших гэрээг бар коджуулахад шаардагдах материалыг бүрдүүлж Нийслэлийн өмчийн харилцааны газраас төвийн I байрны газрын гэрчилгээг бар коджуулан мэдээллийн санд оруулсан. Төвийн II байрны газар ЭМЯ-ны нэр дээр байдаг. 2024 онд хамтран эзэмших шийдвэр гаргуулж, газрын гэрчилгээ холбогдох мэдээллийг шинэчилж авсан. Тус төвийн 1, 2-р байрны газар эзэмших эрхийн гэрчилгээг ЦССУТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/ вэб сайтад байршуулан ил тод байдлыг хангаж байна.	100%
5.5	Төрийн болон орон нутгийн ©мчит, төрийн болон орон нутгийн ӨМЧИЙН	Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно	

	оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дурэм, уйл ажиллагааны чиглэл. эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;		
5.6	Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;	Тус төв нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжээгүй, даатгалд хамрагдаагүй, төсвийн санхүүжилттэй байгууллага. Байгууллагын удирдлага, ажилтан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнд ажилладаггүй.	
5.7	төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;	Түрээсийн гэрээгээр талбай ашиглуулаагүй байна.	
5.8	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	2023 оны 12 дугаар сард УИХ-д өргөн баригдахаар төлөвлөгдөж буй Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулах явцад төвийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийж, 2022 оны 7 дугаар сарын 7-ны өдөр d.parliament.mn вэб сайтад байршуулсан.	100%
5.9	Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт	Төвийн 1-р байрыг 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын 2016/143 дугаар актаар ашиглалтад хүлээн	100%


		авсан. Барилга ашиглалтад оруулах актыг төвийн вэйб сайтад байршуулж ил тод байдлыг хангасан.	
5.10	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно	
5.11	нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно	
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эхийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	2024 онд Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцсан ажилтан байхгүй байна.	
5.13	Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл	Төвийн чиг үүрэгтэй холбоотой хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл байхгүй болно.	


ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГА

ХЯНАСАН:

ЗАХИРГАА МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА

 П.ЭНХЧИМЭГ

 Ч.БАТБОЛД